



**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2024 оны 05 сарын 01 өдөр

Дугаар 191

Улаанбаатар хот

**Албан татвар төлөх хугацааг
сунгах тухай**

Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 40.4-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутаг дэвсгэрт баригдаж байгаа “Алтанширээт” үйлдвэрлэл, технологийн паркийн төслийн барилга угсралтад зориулан “Инфинитиспэйс” ХХК-ийн импортоор оруулж ирэх тоног төхөөрөмж, түүний иж бүрдэлд ногдуулах нэмэгдсэн өртгийн албан татвар төлөх хугацааг 4 жил хүртэлх хугацаагаар сунгахыг Сангийн сайд Б.Жавхланд зөвшөөрсүгэй.

2.Татвар төлөх хугацааг сунгах арга хэмжээг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулахыг Сангийн сайд Б.Жавхлан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар нарт даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

САНГИЙН САЙД

Б.ЖАВХЛАН

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМАНД

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн хуралдааны 13 дугаар тэмдэглэлд:

"7.ХЭЛЭЛЦСЭН нь: Улсын хэмжээнд 2024 онд эзэмшүүлэх, ашиглуулах газрын байршил, хэмжээ, зориулалтын жагсаалтыг батлах тухай

ШИЙДВЭРЛЭСЭН нь: 1.Улсын хэмжээнд 2024 онд эзэмшүүлэх, ашиглуулах газрын байршил, хэмжээ, зориулалтын жагсаалтыг батлах тухай асуудлыг хэлэлцээд тогтоол гаргахаар тогтов.

2.Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийн хэвийн, тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах зорилгоор холбогдох өгөгдөл, мэдээллийн санг хуулбарлан хадгалах, дэд бүтцийн хүчин чадлыг нэмэгдүүлэх талаар арга хэмжээ авч ажиллахыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар (А.Энхманлай) нарт, газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийн нэмэлт хөгжүүлэлт, тоног төхөөрөмжийн шинэчлэлтэд шаардагдах санхүүжилтийг шийдвэрлэх арга хэмжээ авч ажиллахыг Сангийн сайд Б.Жавхланд тус тус даалгав.

3.Аймаг, нийслэл, сум, дүүрэг, чөлөөт бүсийн хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн төлөвлөгөөний мэдээллийг газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системд бүрэн оруулах ажлыг зохион байгуулахыг Барилга, хот байгуулалтын сайд Ц.Даваасүрэн, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар (А.Энхманлай), чөлөөт бүсийн захирагч, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав.

4.Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системд төрийн байгууллагуудын орон зайн өгөгдөл, мэдээллийг холбох ажлыг эрчимжүүлэхийг Засгийн газрын холбогдох гишүүд, албан тушаалтанд даалгав.

5.Цахим системийн мэдээллийг газрын нэгдмэл сангийн ангилал тус бүрээр боловсруулж байхыг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар (А.Энхманлай)-т даалгав." гэжээ.

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМАНД

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн хуралдааны 16 дугаар тэмдэглэлд:

"26.5."Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын хүдрийн овоолгыг ("Ачит ихт" ХХК) ашиглаж байгаа талаар Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан:

1."Ачит ихт" ХХК-тай байгуулсан овоолго ашиглуулах гэрээнд өөрчлөлт оруулж, үндсэн нөхцөл болох төрийн эзэмшлийн 34 хувийг эзэмшүүлээгүй, орхигдуулсан, илт нэг талын эрх ашгийг хангуулж, төрийн өмчийг үнэгүйдүүлсэн гэрээ байгуулан ажилласан байх тул уг нөхцөл байдлыг үүсгэсэн асуудлыг шалгаж, шийдвэрлүүлэх арга хэмжээ авахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаярт, "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ, "Ачит ихт" ХХК-ийн хооронд байгуулсан овоолго ашиглуулах, газрыг хязгаарлагдмал эрхтэйгээр ашиглуулах, цэвэр усаар хангах гэрээнүүдийг болон "Эрдэнэт-Булган цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК болон "Ачит ихт" ХХК-ийн хооронд байгуулсан цахилгаан эрчим хүчээр хангах гэрээг цуцалж, дуусгавар болгон, гэрээ дахин шинээр байгуулахгүй, цаашид төрийн өмчийн эд хөрөнгийг тухайн компанид ашиглуулахгүй байх талаар шуурхай арга хэмжээ авахыг Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Цэнгэл, "Эрдэнэс Монгол" ХХК-ийн гүйцэтгэх захирал С.Наранцогт, "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын ерөнхий захирал Г.Ёндон, "Эрдэнэт-Булган цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК-ийн гүйцэтгэх захирал В.Адъяа нарт даалгав;

2. "Ачит ихт" ХХК болон "Эрдэнэт үйлдвэр" ХХК (хуучин нэрээр)-ийн хооронд байгуулагдсан 2010, 2013 оны гэрээгээр талуудын тохиролцсон 34 хувьд ногдох ногдол ашгийг "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-т нөхөн төлүүлэх болон овоолго ашиглалтаас байгаль орчинд учирсан хохирол, байгаль орчны нөхөн сэргээх төлбөрийн үнэлгээг мэргэжлийн байгууллагаар хийлгүүлж, зохих төлбөрийг гаргуулах талаар шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Б.Цэнгэл, "Эрдэнэс Монгол" ХХК-ийн гүйцэтгэх захирал С.Наранцогт, "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын ерөнхий захирал Г.Ёндон нарт даалгав." гэжээ.

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР